

Arlington County Council



everychild. onevoice.®

Зайн Сургалтын орчинд Хувийн Нууцлалын талаарх Гэр бүлүүдэд хүргэх Мэдээлэл  
2020 оны 09 сарын 07

Энэ баримт бичгийн зорилго нь сурагчид зайн сургалтад хамрагдах явцад хувийн нууцлалын асуудлыг хөндөх, энэ талаарх мэдээллийг гэр бүлүүдэд хүргэхэд оршино. Энэ баримт бичиг нь ямар нэгэн эрхзүйн зөвлөгөө, төлөөлөл болохгүй. Хэрэв танд эрхзүйн туслалцаа шаардлагатай бол танд тулгарсан тодорхой асуудалд хамаарах эрхзүйн мэргэжилтэнтэй зөвлөнө үү.

Арлингтоны оршин суугчид нэн онцгой нөхцөлд, тусгай програм хангамж, видео камерь ашиглан зайнаас суралцаж эхэлсэн энэ үед Эцэг Эх, Багш Нарын Холбоодын Арлингтон хотын Зөвлөл (Arlington County Council of PTAs (*цаашид ССРТА гэх*)) зүгээс Арлингтоны Ерөнхий Боловсролын Сургууль (*Цаашид АЕБС гэх*) болон эцэг эхчүүдэд хандаж хүнд хэцүү цаг үед хүүхдүүдэд чанартай боловсрол олгохын төлөөх хүчин чармайлт, уян хатан байдалд талархаж байна. Харамсалтай нь алсын хараагүй чөлөөт орчин нь тооцоолоогүй сөрөг үр дагаварт хүргэж болох, энэ нь сурагчдын боловсрол, аюулгүй байдал, хувийн нууцлалын асуудалд сөргөөр нөлөөлж болох талтай.

Сурагчид гэрээс зайн шууд (*live*) сургалтад хамрагдсанаар үүсч болох, гэр бүлүүд, сурагчид болон сургуулийн зүгээс хараахан анзаарч үзээгүй ямар бодит эрсдэл байж болох талаар ССРТА идэвхтэй яриа хэлэлцүүлэг өрнүүлж байгаа юм. Бид үндэстэн даяар нэн тодорхой бус нөхцөлд байгаа, тиймээс ч эдгээр асуултуудад тодорхой хариулт олоход ч төвөгтэй юм. **ССРТА-н зүгээс эдгээр асуудлуудыг цаашдын олон нийтийн яриа хэлэлцүүлгийн түвшинд хүргэх, ингэснээр хүн бүр энэ талаар ойлгож, улмаар сурагчдад зайны сургалтыг амжилттай явуулах ажилд нэгдсэн ойлголт, зорилготой болохыг зорьж байна.**

Үндсэн асуудлууд:

- Сурагчийн гэрт болж буй шууд (*live*) видео болон аудио, эдгээрийг бичих, бичлэгийн хадгалалт, ашиглалттай холбоотой хувийн нууцлалыг хамгаалах асуудлууд.
- Багш нар хүссэн хүсээгүй "сурвжалжлагч"-н үүрэг гүйцэтгэх учраас зайны сургалтын үеэр тухайн өрхтэй холбоотой, зан авиртай холбоотой асуудлын гэрч болж, улмаар эрхзүйн асуудал сөхөгдөх боломж.
- Санхүүгийн гачигдал, амьдрах орчны хүндрэлтэй орчин нөхцлийн нууцлал (эдгээр нь шууд болон бичлэгт хэрхэн бичигдэж үлдэх)-н асуудал нь АЕБС-н сурагчдын боловсрол, аюулгүй байдалд шууд хамаарах тул адил тэгш байх зарчимтай холбож авч үзэх нь зайлшгүй.

Юуны өмнө бидний санаа зовоож буй асуудал нь сурагчид хичээлийн өдрүүдэд олон цагаар гэрээсээ өөрсдийн дүрсийг шууд цацах байдал энгийн жишиг болох нь өөрөө тухайн шууд нэвтрүүлгийн үндсэн зорилготой харшлах буюу- тухайлбал чанартай сургалтын чанарын асуудал юм. Ингэж үзэх хэд хэдэн шалтгаанууд нь:

- Камерийн өмнө биеэ барих;
- Сурагчийн ард гарах гэр орны байдал, үзэмжээс санаа зовох;
- Бусдын камерьт харагдах байдалтай сөрөг харьцуулалт хийх;
- Гэр бүлийн бусад гишүүд камерьт санаатай болон санамсаргүйгээр гарснаар сурагч эвгүй байдалд орохоос айх, энэ нь сурагчаас төдийлөн шалтгаалахгүй хүчин зүйл юм;
- Хэрэв сурагч гэр бүлдээ таалагдахгүй зүйлсийг санамсаргүй байдлаар харуулсан нөхцөлд (хууль бус эсэхээс үл хамаарч) шийтгэл хүлээх болон
- Удаан хугацааны турш гадна төрхөндөө анхаарах шаардлагын улмаас стресс үүсэх гэх мэт.

Сурагчид хичээлд анхаарал хандуулах чадваргүй байх АЕБС-н хяналтаас гадна төрөл бүрийн шалтаг шалтгаан байж болох ч **сурагчид хичээлд заавал видео хэлбэрээр оролцож өөрийгөө бусдад харуулах шаардлагатай эсэхийг шийдэх нь харин АЕБС-н мэдлийн асуудал юм.** Тиймээс бид

АЕБС болон сургуулийн удирдлага эцэг эхчүүд, сурагчдад үүнийг маш тодорхой ойлгуулах, сурагчид камераа асаахгүйгээр хичээлд оролцох ямар боломжууд байгааг, энэ нөхцөлд ямар хүндрэл гарч болохыг тайлбарлаж сурталчлахыг уриалж байгаа юм. Нэн ялангуяа дээр дурьдсан сөрөг үр дагаваруудын зарим нь санхүүгийн бололцоогүй, тухайлбал орон байрны хүрэлцээ муу, сурагч камерын өмнө өөртөө итгэлтэй байх орчныг бүрдүүлэх хангамж багатай өрхүүдэд түлхүү хамаарна гэдэг нь ч ойлгомжтой юм. **Хичээлийн үеэр орчин нөхцлийн хувьд боломж муутай сурагчдыг байнгын сэтгэл санааны дарамтад хүргэж болох сургалтын арга барил нь АЕБС-н сурагчдад зохимжгүй юм.**

Мөн үүний зэрэгцээ сурагчдын гэрээсээ оролцож буй видео дүрсийг бичиж авах, үүнийг ч АЕБС-н удирдамжид зарим тодорхой нөхцлүүдэд түгээмэл зөвшөөрч байгаа нь санаа зовоосон асуудал юм. Багшийн видеог бичиж авах нь хичээлийг шаардлагатай үед давтаж үзэх, сургуулийн хувьд багш-сурагч хоорондын ганцаарчилсан сургалтыг бичиж авснаар багштай хожим хариуцлага тооцох гэх мэт олон ашигтай талууд байгааг ССРТА ойлгож хүлээн авдаг.

Харин сурагчийн гэрт байгаа видеог бичиж үлдээх нь ямар ач холбогдолтой нь тодорхой бус, харин ч сөрөг үр дагавар илүүтэй мэт. Бичлэг хийх нь хичээлд гаргасан алдаа мадаг, санамсаргүй сахилга алдах таагүй нөхцлүүдийг баримтжуулж үлдээх, ялангуяа ангийн хүүхдүүд нь хичээлийн жилийн турш тухайн таагүй байдлуудыг нөхөж үзэх эрсдлүүдийг нэмэгдүүлж болох юм. Үүний зэрэгцээ сурагчдын гэрт бичигдэж буй видеонд үлдэх агуулгыг АЕБС хянах боломжгүй, жишээ нь (сурагч, өөр хүүхэд, насанд хүрэгсдийн) нүцгэн бие, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл, АЕБС-д хамаарахгүй гэр бүлийн бусад гишүүдийн хооронд үүсч болох харилцаа гэх мэт гэр бүлүүдийн дотоодын нууцлалд хамаарч болох бусад нөхцөл байдлуудыг дурьдаж болох юм.

Мөн АЕБС-д асран хамгаалагчтай холбоотой болон бусад эрхзүйн маргааны улмаас FOIA<sup>1</sup> хүсэлт ирсэн үед, эсвэл шүүхийн зарлан, хууль сахиулах байгууллагаас, тухайлбал цагаачлалын албанаас шаардсан нэгжлэг зэрэг нөхцлүүдэд эдгээр бичлэгүүдийг хэрхэх тухай бодлого журам, бэлтгэгдсэн боловсон хүчин байгаа эсэх нь санаа зовоох асуудал мөн. Сурагчдын гэртээ байгаа видео болон аудио бичлэгүүдийг хадгалах, хожим нь эдгээрийг сургалттай холбоогүй зорилгоор ашиглах, тодорхой нөхцлүүдэд хууль сахиулах байгууллагад хүлээлгэн өгөх зайлшгүй нөхцөлд орж буйн учир шалтгаан нь юу болохыг ойлгохыг хүсч байна. Төсвийн хүндрэлтэй байгаа энэ цаг үед, АЕБС нь сурагчдын хичээл сургалт, тэдний тусын тулд бус өөр зорилгоор ажилтан авч ажиллуулах нь зохистой эсэхийг ч бодож үзүүштэй.

АЕБС сурагчдад тараасан төхөөрөмж дээр сурагчид өөр бусдын дүрс дууг бичих боломжийг хязгаарлах чадвартай эсэхэд тайлбар хүсч байна. АЕБС зүгээс сурагчдад бусдын гэр орон дахь (хувь хүний нууцлал хамаарах орчин) үйл явдлыг харилцан зөвшөөрөлгүй бичлэг хийхтэй хамаарах Виржиниа мужийн эрүүгийн заалтуудыг сурагчдад тодорхой таниулахыг хүсч байна. Насанд хүрээгүй хүүхдүүд өөрийгөө болон гэр бүлийн бусад гишүүдийн өмнөөс бичлэг хийх зөвшөөрөл өгөх чадамжтай эсэхийг ч тодруулах шаардлагатай.

Эцэст нь ахуйн хүрээний энгийн харилцаанд сургууль оролцсоноор энэ нь мужийн хуулийн дагуу эрхзүйн асуудалд хүргэж болох талаар эцэг эхчүүд сайн бэлтгэлгүй байгаа нь санаа зовоож байгаа юм. **Хүүхдэд сахилга тооцож, шийтгэж буй байдал нь нийтэд шууд хүртээлтэй бичигдэж байгаа, улмаар хүүхэд хүчирхийлэлтэй холбоотой сэжиг бүхий үйлдлийг хүүхэд хамгаалах албанд мэдээлж болох орчинд бэлтгэлгүй олон эцэг эхчүүд бий.** Виржиниа мужийн Халамжийн Үйлчилгээний Яамнаас хуульд зөвшөөрсөн албан ёсны сахилгын шийтгэл, хууль бус хүүхэд хүчирхийлэл хоорондын ялгааг зааглахад асуудал үүсдгийг ч хүлээн зөвшөөрсөн байдаг. Цаашлаад яс үндэс, нийгмийн гарал үүслээр далдуур ялгаварлах байдлын талаар судалгаанууд асар их байдаг нь сахилгын шийтгэлийг үнэлэхэд илүү төвөгтэй болгож байдаг.

Үүний сацуу анхаарал татсан зан авир, тухайлбал сурагчдын өөрт болон бусдад заналхийлсэн үг, үйлдлийг таньж тогтоох үүднээс сургуулийн дүүргүүд заналхийлэл үнэлэх баг бүрдүүлэх дотоод журам мөрдүүлэхийг мужийн хуулиар шаарддаг. Нэг айлын хүүхдүүдийн хооронд үүсдэг, хэрэв энэ нь

---

<sup>1</sup> FOIA- Freedom of Information Act-Нийтийн албаны мэдээллийг гаргуулж авах эрхийн тухай Акт  
*Informational Statement for Families Regarding Privacy During Virtual Learning 9-7-20*

бусдын хараанд өртөх юм уу эсвэл гэр орноос гадна болсон нөхцөлд зүй бусд тооцогдож болох зөрчил маргаанд тухайн гэр бүл дассан байдаг, учир нь эдгээр нь хэн нэгэнд шууд хор хөнөөл болохгүй гэдгийг мэдэж байдагт оршдог. Гэвч хэрэв эдгээр хүүхдүүд зайны сургалтын үеэр гэр орондоо маргах юм уу зодолдох үед багш харж гэрчилсэн бол тухайн сургуулийн заналхийлэл үнэлэх багт хүсэлт гаргаж болох талтай.

Эцэг эхийн энгийн гэж үздэг зан авир багшид сэжигтэй санагдсан үед энэ нь хууль бус, эсвэл заналхийлсэн үйлдэл байж болохыг тодруулахаар асуудал үүсгэж болох мужийн хууль заалт байдгийг эцэг эхчүүд тэр бүр мэддэггүй. Тиймээс гэр бүлд энгийн гэж үздэг шийтгэл, мөн хүүхэд хоорондын зөрчил, маргаан нь албан түвшинд эрхзүйн асуудал үүсгэх нөхцөл байгааг эцэг эхчүүд ойлгох, мөн энэ талаар гэр бүлийн гишүүд болон сурагчидтай ярилцахыг ССРТА зөвлөж байна. Мөн зарим өрхөд бодит ахуйн хүчирхийллийг нуун далдлахуйц орчин бүрдүүлэх чадвартай байхад, хувийн нууцлалаа бүрдүүлэх боломжгүй өрхүүдэд энгийн үг, үйлдэл нь ч эрхзүйн эрсдэлд хүргэж мэдэх нөхцөл байгааг ч ССРТА-н зүгээс онцлох нь зүйтэй.

АЕБС сурагчдын адил тэгш байдлыг сайжруулж, сурагчдыг хууль сахиулах байгуулагад шилжүүлэх явдлыг цөөлж байгаа цаг үетэй давхцаад АЕБС гэр бүлүүдийг гэр орондоо сайн дураар “нэгжлэх хийлгэх” байдалд шууд түлхэж байж болох юм. Эдгээр шууд видео бичлэгүүд нь зөвхөн сурагчдыг өөрсдөөр нь зогсохгүй, тэдний гэр бүлийн гишүүд, тухайн гэр бүлд байгаа хөндлөнгийн хүмүүсийг маш их сөрөг үр дагаварт хөтөлж болох юм. Өөрийн тусдаа өрөөтэй байх боломж бүхий сурагчдад ийм асуудал харьцангуй бага байж болох юм. Гэтэл өөр хүмүүстэй хамт амьдардаг гэр бүлийн сурагчид хичээлд хамрагдах явцад хөндлөнгийн хүмүүс болон өөр сурагчид бичлэгт орж, бичигдэж болох бөгөөд гарах сөрөг үр дагавар ихтэй юм.

Нэгэнт АЕБС-н хувьд гэр бүлүүдийн гэр орныг бичлэг хийх нь зайны сургалтын зорилт биш гэдэг нь ойлгомжтой тул АЕБС гэр бүлүүдэд гарч болох эрсдэл, эдгээрээс зайлсхийх арга замуудын талаар зөвлөгөө үзүүлэхийг уриалж байна.

ССРТА-н зүгээс цаашид дээр дурьдсан асуудлуудын талаар АЕБС-тай хамаарах бүлгүүдтэй санал солилцож, зайны сургалтын сөрөг үр дагавраас урьдчилсан сэргийлж, шийдвэрлэх, сурагчдын боловсрол, хувийн нууцлал, тэдний тусын тулд АЕБС-н хамт олон юу хийж чадах талаар яриа хэлэлцүүлэг өрнүүлнэ гэж найдаж байна.

ССРТА Гүйцэтгэх Хороо:

Emily Vincent, Ерөнхийлөгч

Mary Kadera, Дэд Ерөнхийлөгч

Claire Noakes, Бодлого Хариуцсан Дэд Ерөнхийлөгч

Katherine Novello, Тугсай Төсөл Хариуцсан Дэд Ерөнхийлөгч

Mike O'Leary, Нарийн Бичиг

Kendra Anderson, Нярав (Сан захиран зарцуулагч)